1 – Тендерт оролцох заавар

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ: **СҮХБААТАР АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР (2019-2022), ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ХОРООНЫ 2023-2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ОРОЛЦООНЫ ҮНЭЛГЭЭ ХИЙХ**

Дугаар: **RFP-2026-01**

Огноо: **2026 оны 5 дугаар сарын 11**

Алинеа Интернэйшнл ХХК-ийн хэрэгжүүлж буй *“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулахад орон нутгийн боломжийг нэмэгдүүлэх нь” (ЭККО-ФАРМ)* төслөөс зарласан Зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерт оролцохыг урьж байна. Тендерийн урилга нь дараах бичиг баримтаас бүрдэнэ. Үүнд:

- 1 – Тендерт оролцох заавар
- 2 – Ажлын даалгавар
- 3 – Төсвийн маягт

Хугацаа

Үе шат	Огноо
Тендерийн урилга хүргүүлэх	2026 оны 5 сарын 11
Нэмэлт мэдээлэл, тодруулга авах	2026 оны 5 сарын 15
Санал ирүүлэх	2026 оны 5 сарын 20, 17:00 цаг
Шалгаруулалт	Санал ирүүлснээс хойш 30 хоногийн дотор

Ерөнхий мэдээлэл

Тендерт оролцогчдод тэгш эрх олгох үүднээс энэхүү зааварчилгааг боловсруулсан болно. Энэхүү заавар, ажлын даалгавар болон бусад бичиг баримттай сайтар танилцана уу.

ЭККО-ФАРМ төсөл нь Канад Улсын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр хэрэгжиж буй бөгөөд Олон улсын хөгжлийн туслалцааны хөтөлбөрийн зарчмуудтай уялдана. Дараах холбоостой танилцана уу:

https://www.international.gc.ca/development-developpement/partners-partenaires/bt-oa/Public_version_IDAP-Version_publique_PADI.aspx?lang=eng

1. Худалдан авах ажиллагааг цуцлах, нэмэлт мэдээлэл, тодруулга авах, өөрчлөх

1.1 ЭККО-ФАРМ төсөл нь дараах үйлдлээс үүдэлтэй аливаа үр дагаврыг хариуцахгүй болно:

1.1.1 Тендерт оролцох урилга, худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтийг илгээх;

1.1.2 Тэндерт оролцогчид, түүний төлөөлөлтэй энэхүү худалдан авах харилцаатай холбоотой харилцаа

1.1.3 ЭККО-ФАРМ төсөл (төсөл болон төслийн төлөөлөгч) болон бусад этгээд хоорондын аливаа харилцаа.

1.2 ЭККО-ФАРМ төсөл нь дараах эрхтэй байна:

1.2.1 Ирүүлсэн санал бүрийг хүлээн авахгүй байх;

1.2.2 Тендерийн урилгад тусгасан үйлчилгээг үзүүлэх гэрээ (бүхлээр эсвэл хэсэгчилсэн байдлаар) байгуулахгүй байх;

1.2.3 ЭККО-ФАРМ төсөл нь шалгаруулалтын явцад оролцогчдоос тодруулга авах;

1.2.4 Энэхүү тендер амжилтгүй болсон тохиолдолд ЭККО-ФАРМ төсөл нь өөр хувилбарыг сонгох

1.2.5 Тендер шалгаруулалтын явцад тендэрийн урилгыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах.

1.2.6 Тендерийг дахин зарлах.

2. ТЕНДЕРТ ОРОЛЦОХТОЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ

2.1 ЭККО-ФАРМ төсөл нь энэхүү Тендерийн саналд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд үүнээс үүдэн Тендерт оролцогчдоос гарах аливаа зардал (ажилчид, зөвлөх, гуравдагч этгээд)-ыг Тендерт оролцогч өөрөө хариуцна.

2.2 Тендерийн урилгад оруулсан засвар, нэмэлт, өөрчлөлт, шалгаруулалтын явцад Тендерт оролцогчдоос гарах аливаа зардлыг ЭККО-ФАРМ төсөл нь харицахгүй.

3. САНАЛЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭЛБЭР, ХЭМЖЭЭ, ХУУДАСНЫ ТОО

3.1 Саналын баримт бичгийн хуудасны тоо хэмжээний дээд хязгаар заасан үед Тендерт оролцогч саналын барист бичгийн хуудасны тоог дээд хязгаараас хэтрүүлсэн бол илүү гарсан хуудас бүхий мэдээллийг шалгаруулалтад оруулахгүй.

3.2 Тендерт оролцогчийн саналд тусгагдсан аливаа диаграм, тайлбар, зураг, хүснэгт, хавсралтуудыг нийт хуудасны тоонд оруулж тооцно.

3.3 Хуудасны хэмжээ А4 (цаас эсвэл дижитал) байна.

3.4 Тендерт оролцогчийн саналын баримт бичиг нь Microsoft Word програмын хуудасны Normal хэмжээстэй байх бөгөөд үгийн хэмжээ Arial 11-ээс багагүй (эсвэл ижил хэмжээтэй) байна.

3.5 Тендерт оролцогчдийн саналын баримт бичгийг “Portable document format (.pdf)” өргөтгөлтэй файлаар ирүүлнэ.

4. НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ, ТОДРУУЛГА АВАХ

4.1 Нэмэлт мэдээлэл, тодруулга авах аливаа асуултыг ЭККО-ФАРМ төслийн цахим шууданд ирүүлнэ. Тендэрт оролцогчид нэмэлт мэдээллийг цахимаас өөр хэлбэрээр буюу утсаар эсвэл биеэр ирж авахгүй. Эс бөгөөс шалгаруулалтад оруулахгүй байх нөхцөл үүсэхийг анхаарна уу.

4.2 Нэмэлт мэдээлэл, тодруулга авах хүсэлтийг заасан хугацаанаас өмнө ирүүлнэ.

4.3 ЭККО-ФАРМ төсөл нь тухайн хүсэлтэд тухай бүр хариу өгөхийг эрмэлзэх бөгөөд хариу өгөх хугацаа нь тухайн хүсэлтийн цар хүрээнээс хамаарах болно.

4.4 Тендерт оролцогчдийн тэгш оролцоог хангах үүднээс аливаа хүсэлтийн хариуг (оролцогчдийг дурдахгүйгээр) бүх оролцогчдод илгээнэ.

4.5 Тендерт оролцогч асуултаа илгээхдээ өөрт холбоотой нууцлалын зэрэгтэй мэдээлэл агуулсан бол түүнийгээ мэдэгдэх.

4.6 ЭККО-ФАРМ төсөл нь тухайн асуулт нь нууцлалын зэрэгтэй эсэхэд эргэлзэж байгаа тохиолдолд Тендерт оролцогчийг асуултаа өөрчлөх эсвэл эгүүлэн татах боломжийг олгоно. Засварлаж өөрчлөөгүй асуултын хариуг нийт оролцогчдод илгээхийг анхаарна уу.

5. ТЕНДЭРИЙН САНАЛ ИРҮҮЛЭХ

5.1 Тендэрт оролцогчид саналаа ЭККО-ФАРМ төслийн худалдан авах ажиллагааны procurement@ecco-farm.mn цахим шууданд заасан хугацаанаас өмнө ирүүлнэ.

5.2 Баримт бичгийн хэмжээ 20МВ-ээс хэтрэхгүй бөгөөд хэтэрсэн тохиолдолд ЭККО-ФАРМ төслийн шууданд ирэхгүй байх магадлалтайг анхаарна уу. Заасан дээд хязгаараас хэтэрсэн хэмжээтэй файлыг хавсаргахаас өмнө хэмжээг багасгана уу.

5.3 Цахим шуудан нь файлын хэмжээ, өргөтгөл, холбоос, вирус зэргээс үүдэн имэйл явахгүй/ирэхгүй байх нь ЭККО-ФАРМ төслийн цахим шуудангийн хамгаалалтын системээс хамаарах бөгөөд Тендерт оролцогч болон ЭККО-ФАРМ төсөлд мэдэгдэл ирэхгүйгээр имэйл илгээх нь амжилтгүй болох магадлалтай. Үүнээс үүдэх аливаа асуудлыг ЭККО-ФАРМ төсөл харицахгүй бөгөөд харин хүлээн авсан санал бүрт санал хүлээн авсан тухай мэдэгдэл хүргүүлнэ.

5.4 Тендерт оролцогчид дараах нөхцлийг хүлээн зөвшөөрнө:

5.4.1 Шалгаруулалтад шаардлагатай нэмэлт мэдээллийг заагдсан хугацаанд гаргаж өгөх;

5.4.2 Тендерийн саналд тусгагдсан аливаа мэдээллийн дэлгэрэнгүйг өгөх;

5.4.3 Тендерийн урилгын нөхцлийг хангах, эс бөгөөс саналыг шаардлага хангаагүйд тооцох.

5.5 Тендерийн бүх бичиг баримт дараах шаардлагыг хангасан байна:

5.5.1 Тендэрийн саналыг англи эсвэл монгол хэлээр бэлдэх;

5.5.2 Тендерийн урилгад заасан бүх баримт бичиг бүрэн байх.

5.5.3 Санхүүгийн саналыг маягтын дагуу бэлдэх. Санхүүгийн бус мэдээллийг техникийн саналд тусгах.

6. ШАЛГАРУУЛАЛТ

6.1 Ирүүлсэн бүх саналыг тухайн саналд тусгагдсан мэдээлэл болон ЭККО-ФАРМ төслөөс шаардсан нэмэлт мэдээлэлд үндэслэн шалгаруулна.

6.2 Эдийн засгийн хувьд хамгийн сайн саналыг шалгаруулахдаа техникийн болон санхүүгийн саналыг үнэлж тодорхойлно.

6.3 ЭККО-ФАРМ төсөл нь хамгийн сайн саналыг тодорхойлох боломжгүй тохиолдолд Тендерт оролцогчдоос нэмэлт мэдээлэл авч түүнд үндэслэн шийдвэр гаргах эрхтэй.

ECCO-FARM

“УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ, ДАВАН ТУУЛАХАД ОРОН НУТГИЙН БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” (ЭККО-ФАРМ) ТӨСӨЛ

СҮХБААТАР АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР (2019-2022), ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ХОРООНЫ 2023-2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ОРОЛЦООНЫ ҮНЭЛГЭЭ ХИЙХ

АЖЛЫН ДААЛГАВАР

1. Төслийн танилцуулга

“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулахад орон нутгийн боломжийг нэмэгдүүлэх нь” (ЭККО-ФАРМ) төсөл нь уур амьсгалд зохицсон ухаалаг ХАА, ХАА-н байгальд суурилсан шийдлүүд, биологийн олон янз байдлыг хамгаалах арга аргачлалыг нэвтрүүлэх замаар ХАА-н салбар болон тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход орон нутгийн иргэдэд дэмжлэг үзүүлнэ. ЭККО-ФАРМ төсөл нь ХАА, байгаль орчин, орон нутгийн хоорондын уялдаа холбоог харгалзан үзэх замаар эрх тэгш байдлыг хангасан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хүнсний аюулгүй байдлын тогтолцоонд хувь нэмэр оруулах юм. Нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх, хөрс, усны чанарыг сайжруулах шинэлэг арга барилыг нэвтрүүлснээр ХАА-н салбарын бүтээмжийг дээшлүүлж, биологийн олон янз байдлыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх бөгөөд уур амьсгалын гэнэтийн өөрчлөлтийг даван туулах чадварыг сайжруулна. Нэмүү өртгийн сүлжээний шинэлэг арга аргачлалыг ХАА-н үйлдвэрлэлд нэвтрүүлснээр иргэд бүтээгдэхүүнийхээ үнэ цэнэ болон ашиг орлогоо нэмэгдүүлж, улмаар ядуурлыг бууруулахад, мөн хүнсний аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулах юм.

Зорилго: Эдийн засгийн хөгжил болон эмэгтэйчүүд, залуучуудын оролцоог түлхүү харгалзан үзэх замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, биологийн олон янз байдлыг алдагдуулахгүйгээр орон нутагт ХАА-н хүнсний тогтолцооны чадавхыг сайжруулахад оршино.

Хүснэгт 1. ЭККО-ФАРМ төслийн товч танилцуулга

Төслийн нэр:	**Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулахад орон нутгийн боломжийг нэмэгдүүлэх нь (ЭККО-ФАРМ) 5 жилийн хугацаатай хэрэгжих төсөл (2024-2029)**
Хамтран ажиллах байгууллагууд:	• Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) • Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ) • Жендэрийн үндэсний хороо (ЖҮХ)
Төслийн байршил:	Монгол Улсын ХАА уур амьсгалын 2 бүс, тэр дундаа - Хангайн бүсийн Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгууд - Тал хээрийн бүсийн Сүхбаатар, Дорнод аймгуудад хэрэгжинэ.
Хэрэгжүүлэгч байгууллагууд:	Алинеа Интернэйшнл ХХК (Канад), Албертагийн Биологийн олон янз байдлын мониторингийн хүрээлэн (Канад), болон БлакРок Партнерс ХХК (Монгол)

2. Үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх чиглэл болон 2011 онд батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн дагуу 21 аймаг жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн дэд хөтөлбөр, зохих бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлж хэвшсэн билээ. Энэ хүрээнд Сүхбаатар аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөрийг 2019 оны 10-р сарын 15-ны өдрийн 62-р тогтоолоор баталж, 2019-2022 онд хэрэгжүүлсэн юм.

Жендэрийн суурь судалгаа болох “*Орон нутгийн жендэрийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа*”-ны үр дүн, аймгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан боловсруулсан тус дэд хөтөлбөрийн зорилго нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль

тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг эрчимжүүлж, төр иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэн, улс төр, эдийн засаг, нийгэм-соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангахад оршдог. Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлж, хамтын ажиллагааг дээшлүүлэх
3. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх
4. Жендэрт суурилсан хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд төр, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах

Түс хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш Сүхбаатар аймгийн Жендэрийн салбар хорооноос жендэрийн чиглэлийн үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх, орон нутгийн жендэрийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор 2023-2026 онд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсээр ирсэн. Мөн Сүхбаатар аймаг нь орон нутагтаа жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг нэвтрүүлэх чиглэлд Канадын Засгийн газрын санхүүжилттэй МЕРИТ (*Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь*), Ногоон уур амьсгалын сангийн санхүүжилттэй АДАПТ (Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь), “Дасан зохицохуйн зам: Малчин – мал амьтан – тал хээрийн цогц эрүүл мэнд” зэрэг хөгжлийн хамтын ажиллагааны төслүүдтэй хамтран ажиллаж байгааг дурдах нь зүйтэй.

Гэвч өмнө хэрэгжсэн уг хөтөлбөр, түүнээс хойш салбар хорооноос хэрэгжүүлсэн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хөндлөнгийн үнэлгээ хараахан хийгдээгүй байна (ЖҮХ, 2025[1]). ЖҮХ-ны зүгээс орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэхэд гарсан ахиц амжилт, зөрүүтэй байдал, бэрхшээл, сургамжийг тодорхойлж, дараагийн шатны жендэрийн чиглэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, сумын ард иргэдэд үзүүлэх нөлөөллийг нь сайжруулах үүднээс хөндлөнгийн үнэлгээ хийхийг зөвлөж байна.

ЭККО-ФАРМ төслийн Бүрэлдхүүн 1300 нь төсөл хэрэгжиж буй аймаг, сумдын охид, эмэгтэйчүүдийн байгаль орчны засаглал, уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон ухаалаг ХАА, ХАА-н байгальд суурилсан шийдлүүдийг хэрэглэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээн дэх оролцоо, манлайллыг нь дээшлүүлэхэд чиглэсэн. Энэ хүрээнд орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран ажиллаж, бодлого, хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй хүргэх чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг зорин ажиллаж байна. Иймд жендэрийн өөрчлөлтийн арга хандлагынхаа хүрээнд ЭККО-ФАРМ төсөл нь хөндлөнгийн үнэлгээг оролцооны арга хандлагаар хийлгэхэд нь дэмжлэг үзүүлж, аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр, үйл ажиллагааны үр дүн, нөлөө, тогтвортой байдал, хүртээмжийг үнэлэх юм.

ЭККО-ФАРМ төслийн зөвлөх үйлчилгээнээс хүлээж буй үр дүн:

Гарц 1311: Эмэгтэйчүүдийн хэрэгцээ/саад бэрхшээлийн талаарх судалгааг хийх, мөн салбарын яамд, орон нутгийн засаг захиргааны уур амьсгалын бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх, төсөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавх сайжруулах төлөвлөгөө боловсруулах

Үйл ажиллагаа 1311.4: Сүхбаатар аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр, жендэрийн чиглэлийн бодлого, үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийх

[1] https://www.ncge.gov.mn/wp-content/uploads/2026/03/%D0%9C%D0%A3%D0%97%D0%93%D0%A2-2025.pdf

Үйл ажиллагаанаас гарах үр дүн:

- Үнэлгээний тайлан (Монгол хэл дээр)

Үнэлгээний зорилго:

- Сүхбаатар аймагт 2019-2022 онд хэрэгжсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөр, түүнээс хойш хэрэгжүүлсэн Жендэрийн салбар хорооны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний үр дүн, нөлөө, тогтвортой байдал, хүртээмжийг үнэлэх
- Орон нутгийн онцлог бүхий жендэрийн асуудлыг тодорхойлох. Энэ хүрээнд боловсролын салбар дахь жендэрийн асуудлыг гүнзгийрүүлэн судлах
- Үнэлгээний үр дүнд тулгуурлан дүгнэлт, зөвлөмж боловсруулах

3. Үнэлгээний аргачлал

Зөвлөж буй арга:

ЖҮХ-ноос 2025 онд төрийн бус байгууллага (ТББ)-уудад зориулан гаргасан “Хяналт шинжилгээ, үнэлгээний гарын авлага”[2]-д тулгуурлан анхдагч мэдээлэл цуглуулах дараах аргуудыг ашиглах бөгөөд зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй болно. Үүнд:

a. Асуулга: Сонгогдсон гол оролцогч болон холбогдох бусад талуудаас тоон мэдээлэл цуглуулах зорилгоор асуулга явуулах
b. Ганцаарчилсан ярилцлага: Хөтөлбөрийг хариуцсан албан хаагч, үр шим хүртэгч болон орон нутгийн удирдлагуудтай хагас бүтэцжсэн ярилцлага хийх
c. Фокус бүлгийн хэлэлцүүлэг: Гүнзгий чанарын мэдээлэл цуглуулах үүднээс бүлгийн хэлэлцүүлэг хийх
d. Ажиглалт: Энэ чиглэлийн үйл ажиллагаанд ажиглалт хийх
e. Баримт бичгийн судалгаа, агуулгын шинжилгээ: Хөтөлбөрийн болон Сүхбаатар аймгийн холбогдох баримт бичиг, төлөвлөгөө, тайлан, архивын баримтад шинжилгээ хийх
f. Сүхбаатар аймагт уур амьсгалын өөрчлөлт, жендэрийн чиглэлээр хэрэгжиж буй төслийн төлөөллүүдтэй уулзалт хийх
g. Үнэлгээний тайланг эцэслэх зорилгоор Сүхбаатар аймгийн Жендэрийн салбар хороог хуралдуулж, үр дүнг танилцуулан баталгаажуулах

Гэрээлсэн үнэлгээний баг нь оролцогч талуудаас ялгаатай аргуудаар цуглуулсан мэдээллийг хооронд нь тулган баталгаажуулах (triangulation) үүднээс дээр дурдсан тоон болон чанарын мэдээлэл цуглуулах хэрэглүүрүүдийг боловсруулан ашиглана. Мөн үнэлгээний баг “Дүн шинжилгээний хүрээ”, судалгааны тухайлсан арга хэрэглүүрүүд (өөрөөр хэлбэл, асуулга, ярилцлагын удирдамж, загвар маягт, түүврийн төлөвлөгөө)-ийг боловсруулах явцад ЭККО-ФАРМ төслийн төлөөллүүдийн зүгээс хянан үзэж, зохих санал зөвлөмжөөр хангана.

Оролцооны арга хандлага:

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ), агентлаг, тэдгээрийн удирдлага, мэргэжилтнүүдийн зохих оролцоог хангах үүднээс ажлын баг байгуулах бөгөөд бүрэлдэхүүнд нь Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, үнэлгээний багийн гишүүд, ЭККО-ФАРМ төслийн төлөөлөл, ЖҮХ-ны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн нар багтана. Үнэлгээний багийн зүгээс оролцогч талуудтай ярилцан тохиролцсоны үндсэн дээр талуудын оролцооны үүрэг, хариуцлагыг нарийвчлан тогтох бөгөөд ерөнхий оролцоо нь дараах байдалтай байна. Үүнд:

[2] ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭНИЙ-ГАРЫН-АВЛАГА_compressed-1.pdf

- Аймгийн салбар хорооны зүгээс зохих мэдээллээр хангах, холбогдох мэргэжилтэн, албан хаагчдын оролцоог хангах, үнэлгээний талбарын ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, үнэлгээний багт дэмжлэг үзүүлэх ажлын багт орж ажиллах үүрэг хүлээнэ.
- ЭККО-ФАРМ төсөл нь сонгогдсон орон нутгийн ТББ-ын зөвлөх багт мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх, үнэлгээнд чанарын хяналт тавих ажлыг хариуцна.
- ЖҮХ-ноос үнэлгээ жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний бодлого, хөтөлбөртэй нийцсэн байдал, аргазүйн хувьд тохирч байгаа эсэхийг баталгаажуулах үүрэг хүлээнэ.
- Үнэлгээний баг нь үнэлгээг өндөр чанартай гүйцэтгэх, оролцогч талуудыг тодорхойлох, сургалтыг зохион байгуулах, Жендэрийн салбар хороог хуралдуулж, үнэлгээний үр дүнг танилцуулж, баталгаажуулах үүрэг хүлээнэ. Мөн төрийн холбогдох албан хаагчдыг чадавхжуулах, үр дүнгийн тогтвортой байдлыг хангах /тайланг танилцуулах, хүлээлгэн өгөх/ асуудлаар MERIT төслийн хамтын ажиллагааны хүрээнд гүйцэтгэнэ.

Ёс зүйн зарчмууд:

Гэрээлэгч нь төсөлтэй гэрээлсний дагуу ажил гүйцэтгэж байгаагаа харгалзан үзэж, үнэлгээ эхлэхээс дуусах хүртэл ёс зүйн дараах зарчмуудыг баримтлах нь зүйтэй. Үүнд:

- Төсөл болоод төслийн төлөөллийн нэр хүнд, алдар, имижэд сөргөөр нөлөөлөх мэдэгдэл хийх, мэдээлэл өгөх
- Төслийн талаар буруу, дутуу, худал мэдээлэл өгөхөөс зайлсхийх үүднээс төсөлтэй холбоотой тодруулга, мэдээллийг төслийн мэргэжилтнээс авахыг хэлэх, холбож өгөх
- Үнэлгээнд хамрагдагсдын нууцлалыг хангах, алив сөрөг хандлагын бай болохоос хамгаалах, шүүж, шүүмжлэхээс зайлсхийх
- Оролцох зөвшөөрлийг нь авч, баримтжуулах
- Үнэлгээнд хамрагдагсадтай эрх мэдлийн хувьд тэнцвэртэй, тэгш харилцааг үүсгэх
- Хараат бус байх, төвийг сахих, үнэлгээд итгэх байдлыг хангах, шударга байх, талуудын өмнө хариуцлага хүлээх, гэрээлсэн хугацаанд өндөр чанартай бүтээгдэхүүн бий болгох үүрэг хүлээх
- Дата мэдээллийг хуулийн дагуу хадгалж, үнэлгээний төгсгөлд төсөлд хүлээлгэн өгөх

Бодлогын гол баримт бичгүүд:

1. Алсын хараа 2050
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
3. Хөдөлмөрийн тухай хууль
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги 2022-2031
5. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
6. Аймгийн хөгжлийн баримт бичгүүд, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
7. ЖҮХ-ны Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрт оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал
8. ЖҮХ-нд хүргүүлсэн Жендэрийн салбар хорооны тайлангууд
9. Сүхбаатар аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр (2019-2022) болон түүнээс хойш батлан хэрэгжүүлсэн Аймгийн Жендэрийн салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд, тэдгээрийн хэрэгжилт/биелэлтийн тайлан, мэдээ
10. Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого
11. Сүхбаатар аймгийн Орон нутгийн жендэрийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааны тайлан
12. Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)
13. Аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангууд
14. Жендэрийн чиглэлийн болон техникийн бусад баримт бичгүүд
15. Зохих захиргааны баримт бичгүүд

16. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой баримт бичиг, тайлан мэдээнүүд
17. Мэдээлэл, харилцааны баримт бичгүүд

4. Зөвлөх үйлчилгээнээс гарах бүтээгдэхүүн

Гол бүтээгдэхүүнүүд нь:

1. Эхлэл тайлан: Баримтын судалгаа, арга зүй, дүн шинжилгээний хүрээ, үнэлгээний хэрэглүүрүүд, ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөг агуулна.
2. Сургалт: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, сайжруулалтын чиглэлээр 1 өдрийн сургалтын агуулга, слайд, тараах материал, хөтөлбөр, оролцогчдын жагсаалтыг гаргана.
3. Үнэлгээний тайлан: Үр дүн, дүгнэлт болон зөвлөмжийг агуулна. Хавсралтаар хэрэглүүрүүд, түүхий, боловсруулсан болон дүн шинжилгээ хийсэн дата мэдээлэл, сургалтын модуль, бүртгэл, үнэлгээний хуудас, зураг зэргийг системтэйгээр оруулна.

Гол агуулга нь:

- **Бэрхшээл:** Дэд хөтөлбөр болон түүнээс хойш хэрэгжүүлсэн үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдэд тулгуурлан жендэрийн асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхэд тулгарч буй саад, бэрхшээлийг тодорхойлох
- **Ахиц амжилт, боломж**: Аймгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлж, дараагийн бодлогын баримт бичигт тусгавал зохих ахиц амжилт, сайн туршлагыг тодорхойлж, баримтжуулах
- **Хөтөлбөр сайжруулахад чиглэсэн зөвлөмж**: Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц болон үр нөлөөг нь сайжруулахад чиглэсэн зөвлөмж боловсруулах
- **Чадавхжуулах хэрэгцээ**: ЗДТГ, холбогдох агентлагуудын албан хаагчид болон бусад оролцогч талуудыг жендэрийн чиглэлээр сургах, чадавхжуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох
- **Бодлогын үр дагавар:** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах санал санаачилга, арга хэмжээг хэрхэн дэмжвэл зохих талаар үндэсний болон орон нутгийн бодлого боловсруулагчдад зориулсан зөвлөмж
- **Цаашид гүйцэтгэх шаардлагатай судалгаа, үнэлгээ**: Гүнзгийрүүлэн судлах болон урт хугацааны үр нөлөөнд нь тасралтгүй ХШҮ хийх шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлох
- **Сонгосон жендэрийн асуудлын судалгаа**: Сүхбаатар аймгийн зүгээс боловсролын салбарын жендэрийн асуудлыг гүнзгий судлуулахыг хүссэн.
- **Жендэрийн бодлогын баримт бичигт чиглэсэн ерөнхий зөвлөмж**: Өмнөх дэд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс гарсан сургамж, дараагийн жендэрийн бодлогын баримт бичигт жендэрийн ямар асуудлыг, хэрхэн шийдвэрлэхээр тусгавал зохих талаар тодорхой стратеги, боломжуудыг тодорхойлох, жендэрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх практик зөвлөмж боловсруулах

Агуулгын хувьд зөвхөн дээрхээр хязгаарлагдахгүй болно.

5. Үргэлжлэх хугацаа:

Үнэлгээг дараах ажлын төлөвлөгөөнд заасны дагуу 36 ажлын өдөрт багтаан гүйцэтгэнэ. Сонгогдсон үнэлгээний баг талбар дээр гүйцэтгэх ажилтай уялдуулан төлөвлөгөөг нарийвчлан боловсруулна.

Хүснэгт 2. Гүйцэтгэх ажил, шаардагдах хугацааг заасан ажлын урьдчилсан төлөвлөгөө

Үр дүн	Гүйцэтгэх ажил	Ажлын өдөр	Шаардлагатай хяналт, баталгаажуулалт

Эхлэл тайлан	Баримт бичгийн судалгаа хийх, дүн шинжилгээний хүрээг (ө.х зохих түүврийн төлөвлөгөө, асуулга, ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн хэлэлцүүлэг, гүнзгийрүүлсэн ярилцлагын удирдамжуудын хамт) боловсруулах, холбогдох талуудтай эхлэл уулзалт хийх	7 өдөр	Ажлын баг, төслийн зүгээс хянан үзэж, санал зөвлөмж өгөх
Сургалтын модуль	ЖҮХ-ны гарын авлагад тулгуурлан сургалтын агуулга, хөтөлбөр, слайдууд, сургалтын өмнөх болон дараах үнэлгээний хуудсуудыг боловсруулах	5 өдөр	Ажлын баг, төслийн зүгээс хянан үзэж, батлах
Мэдээлэл цуглуулах ажил, сургалт	Сүхбаатар аймагт сургалт зохион байгуулах, мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэх (Үүнд: асуулга авах, ярилцлага, фокус бүлгийн хэлэлцүүлэг, оролцогч талуудтай хийх уулзалтыг зохион байгуулах, Жендэрийн салбар хорооны хуралдаан, ажлын багийн уулзалтад оролцох). Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн дэмжлэг үзүүлж ажиллана.	10 өдөр	Шаардлагатай тохиолдолд ажлын багийн гишүүдтэй ахиц, бэрхшээлийн талаар тухай бүр нь хэлэлцэх
Үнэлгээний урьдчилсан тайлан	Дүгнэлт, зөвлөмж бүхий үнэлгээний тайланг урьдчилсан байдлаар боловсруулж, хүргүүлэх	10 өдөр	ЭККО-ФАРМ төслийн зүгээс танилцаж, санал зөвлөмж өгөх
Үр дүнг баталгаажуулах хурал	Үнэлгээний урьдчилсан үр дүнд тулгуурлан илтгэл бэлтгэж, үр дүнг Жендэрийн салбар хорооны гишүүдэд танилцуулж, баталгаажуулах уулзалт зохион байгуулах. Энэ хүрээнд илтгэл танилцуулга бэлтгэнэ.	2 өдөр	Ажлын баг болон гол оролцогч талуудын төлөөлөл үнэлгээний үр дүнтэй танилцаж, сайжруулах санал, зөвлөмж хэлэх
Үнэлгээний эцсийн тайлан (Монгол хэл дээр)	Урьдчилсан тайланд зохих өөрчлөлтийг оруулж, эцсийн тайланг бэлтгэн ирүүлэх. Мөн үнэлгээний хүрээнд цуглуулсан анхдагч өгөгдөл, мэдээллийг (тухайлбал, эмхэтгэсэн тоон болон чанарын мэдээлэл, бүртгэлийн хуудас, ганцаарчилсан болон гүнзгийрүүлсэн ярилцлага, фокус бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэл, үр дүнг баталгаажуулах семинараас гарсан зөвлөмж) хүлээлгэн өгнө. Бүхий л мэдээллийг хүйс, нас, ажил эрхлэлтийн байдлаар ангилсан байна.	2 өдөр	Ажлын багийн зүгээс танилцаж, санал зөвлөмж өгөх

6. Үнэлгээний багийн бүрэлдэхүүн

Үнэлгээний ажлыг мэргэжлийн, хүлээн зөвшөөрөгдсөн Сүхбаатар аймгийн үнэлгээний баг (өөрөөр хэлбэл, ТББ, компани, эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны байгууллага, багийн зохион байгуулалтад орсон бүлэг хүмүүс зэрэг) гүйцэтгэнэ. Улаанбаатар хот болон бусад

байршлаас жендэрийн чиглэлээр мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, чиглүүлэх мэргэжилтэнтэй бол давуу тал болно.

Үнэлгээний багийн бүрэлдэхүүнд бодлогын үнэлгээ хийх, жендэрийн чиглэлийн судалгааг удирдан чиглүүлэх, жендэрийн сургалт, семинар, хэлэлцүүлгийг чиглүүлэх арвин туршлагатай багийн Ахлагч болон жендэрийн чиглэлийн мэдээлэл цуглуулж, боловсруулах, өндөр түвшний мэргэшил, туршлагатай мэргэжлийн судлааач(ид) багтвал зохино.

Тавигдах шаардлага

- Үнэлгээний ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, шахуу хуваарийн дагуу ажиллах чадвар бүхий зохион байгуулалт сайтай байх
- Ахисан түвшний судалгааны аргачлалыг ашиглан олон чиглэлийн цогц судалгаа, үнэлгээ дор хаяж 5 жил хийсэн туршлагатай байх
- Багийн гишүүн/гишүүд Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан Оролцооны хяналт, шинжилгээ, үнэлгээний сургалтанд хамрагдсан байх
- Өмнө нь оролцоонд суурилсан жендэрийн аудит, хөндлөнгийн болон оролцооны үнэлгээ хийж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Жендэрийн дэд хөтөлбөрт оролцооны арга хандлага ашиглан үнэлгээ хийх мэдлэгтэй байх
- Ижил төстэй 2 судалгааны ажлыг амжилттай гүйцэтгэсэн байх;
- Зохих хугацаанд орон нутгийн төрийн байгууллагууд, оролцогч талуудтай хамтран ажиллаж байсан туршлагатай байх
- Онцлог хэрэгцээ бүхий оролцогч талуудтай ажиллах, мэргэжлийн бөгөөд дипломат түвшинд харилцах туршлагатай байх
- Бие даан болон багаараа цуглуулсан мэдээллийг эмхэтгэж, боловсруулах ур чадвартай байх

Материал ирүүлэх үйл явц

Сонирхсон баг нь дараах баримт бичгийг бэлтгэн (1 PDF файланд багцлан) 2026 оны 5-р сарын 20-ны 17:00 цагийн дотор procurement@ecco-farm.mn хаягт “RFP-2026-01” хэмээн гарчиглаж ирүүлнэ. Үүнд:

1. Сонирхлоо илэрхийлсэн албан захидал
2. Өмнө гүйцэтгэсэн судалгааны ажил, тайлангийн товч танилцуулга (1 хуудаснаас хэтрэхгүй)
3. Багийн гишүүдийн намтар (CV)
4. Техникийн санал
5. Санхүүгийн санал (зардлын задаргааг оруулах)